

# Комплаенсийн үйл ажиллагааны тайлан - 2025



2025 оны хоёрдугаар хагас жил

## Агуулга

- Комплаенсийн үүрэг
- ISO стандарт
- Комплаенсийн эрсдэл
- Комплаенсийн байнгын сайжруулалт
- Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилт

Компани 2025 оны хоёрдугаар хагас жилд комплаенсийн үүргийн хэрэгжилтэд хяналт тавьж хууль, журмын нийцлийг хангуулах, комплаенсийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх, комплаенсийн соёлыг бэхжүүлэх, ач холбогдлыг таниулах ажлуудыг үе шаттайгаар хэрэгжүүлж Мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хууль, дотоод журмын шаардлагыг ханган ажиллаа.

## Комплаенсийн үүрэг

*Заавал дагаж мөрдөх үүрэг:* Тайлант хугацаанд компанийн үйл ажиллагаанд хамраалтай хууль тогтоомж, дүрэм, журмын дагуу төрийн эрх бүхий зохицуулагч байгууллагуудад 19 төрлийн тайлан мэдээг давтагдсан тоогоор 181 удаа хүргүүлж, комплаенсийн үүргийн нийцлийг хангалаа.

*Дагаж мөрдөх үүрэг:* Компанийн дотоод дагаж мөрдөх үүргийн хэрэгжилтэд тогтмол хяналт тавьж, удирдлагын хороодод тайлагнан, комплаенсийн эрсдэл үүсч болзошгүй тохиолдлуудад санал, зөвлөмж бэлтгэн хүргүүлж ажиллаа.

- *Олон Улсын зах зээлд гаргасан Хулан бонд:* Хулан бондын гэрээгээр хүлээсэн үүргийн дагуу төлбөрийг хуваарийн дагуу төлж, тайлан болон бусад мэдээллийг цаг хугацаанд нь хүргүүллээ.
- *Ипотекийн зээлээр баталгаажсан бонд:* Тайлант хугацаанд тус бондын төлбөрүүдийг цаг хугацаанд нь төлж, хэлцэл эрхлэн гүйцэтгэгч, хөрөнгө

итгэмжлэн удирдагчийн үйл ажиллагааг хэрэгжүүлэн холбогдох тайлан мэдээг зохих хугацаанд хүргүүллээ.

- МИК дотоодын бондуудын эргэн төлөлтүүдийг амжилттай төлж дуусган үлдэгдэлгүй болсон байна.

## ISO стандарт

Дараах Олон улсын стандартуудын шаардлагыг хангаж, үйл ажиллагаандаа нийцүүлэн хөндлөнгийн аудитын байгууллагаар баталгаажуулан байнгын сайжруулалтыг тасралтгүй хэрэгжүүллээ.

- ISO/IEC 27001:2022 Мэдээллийн аюулгүй байдал;
- ISO 31000:2015 Эрсдэлийн удирдлага;
- ISO 37301:2021 Комплаенсийн удирдлага.

## Комплаенсийн эрсдэл

Тайлант хугацаанд комплаенсийн эрсдэлийн үнэлгээнд өөрчлөлт ороогүй, ёс зүйн зөрчилийн тохиолдол гараагүй. Мөн харилцагч нараас аливаа санхүүгийн, үйл ажиллагааны болон нэр хүндийн эрсдэл үүсэхүйц гомдол санал гараагүй.

## Комплаенсийн байнгын сайжруулалт

*Сургалт, хөгжил:* Тайлант хугацаанд шинэ ажилтнуудад улирал бүр, нийт ажилтнуудад цахим цуврал сургалт, мэдээллийг сар бүр тогтмол хүргүүлж комплаенсийн соёлыг төлөвшүүлж, комплаенсийн эрсдэл үүсч болзошгүй нөхцөл байдлаас урьдчилан сэргийлж ажилласан.

*Тайлагнал:* Комплаенсийн үүргийн хэрэгжилтийн хяналтыг сар бүр хэрэгжүүлж Удирдлагын хороонд тайлагнадаг. Мөн түүнчлэн комплаенсийн чиг үүргийн хүрээнд компанийн үйл ажиллагааг сайжруулах, эрсдэлээс урьдчилан сэргийлэхтэй холбоотой санал

зөвлөмжийг агуулсан комплаенсийн үйл ажиллагааны тайланг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дэргэдэх Эрсдэлийн Удирдлагын Хороонд бэлтгэн танилцууллаа.

Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилт

Монгол улсын Мөнгө Угаах Терроризмыг Санхүүжүүлэхтэй Тэмцэх тухай хууль болон олон улсын гэрээ, хориг арга

хэмжээнүүдийн шаардлагын дагуу компанийн харилцагч банк санхүүгийн байгууллагууд, олон улсын хамтын ажиллагааны байгууллагуудад харилцагчийг таньж мэдэх шинжилгээг хийн эрсдэлээс урьдчилан сэргийлж, тогтмол хяналт тавьж ажиллаа.

Хянан нийцүүлэлтийн газар

